



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Холбогдох хууль журмыг мөрдөж ажиллаагүйгээс хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5.2 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ ашиглалтгүй байна.

Аудитын дүгнэлтээс 2025 он



# "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт" нийшлийн аудитын тайлангаас

## АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Аудитад Дархан-Уул аймагт 2024 онд батлагдсан 37 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулав.

### ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Тоо: **6**



Мөнгөн дүн: **61.9** тэрбум төгрөг



### ГОЛ ЗӨРЧИЛ



Аудитаар нийт **61,916.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 410.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 61,506.0 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө. хүргүүлсэн.



Зураг, төсөв боловсруулж, магдлаар баталгаажуулах, барьцаа хөрөнгийн дансад байгаа хяналт, нормчиллол, зөвлөх үйлчилгээ, зураг төсвийн зардлыг холбогдох дансанд төвлөрүүлэх, ТАХ-ний зураг төсөв, техникийн тодорхойлолт бусад холбогдох материалыг ХААГ-т цаг алдалгүй хүргүүлж байх, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч данс бүртгэлд бүртгүүлэх, захиалагчийн хяналтыг сайжруулах, Өмчийн газар 2023 оны 278 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах зөрчилд **61,506.0** сая төгрөгийн 6 зөвлөмжийг Дархан-Уул аймгийн Засаг дарга, ДХББЗГ ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр, ОНӨГ-ын дарга Д.Бат-Эрдэнэ нарт хүргүүлсэн.

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



Цахим анги байгуулах



Боловсрол, Соёл, Эмнэлэгийн салбарын тоног төхөөрөмж



Спорт цогцолбор 2200



Цэвэрлэх байгууламжийн шинэчлэл



Шүүхийн шинжилгээний төвийн их засвар  2,997.0 сая төгрөгийн Шинэ хөдөө төсөл 3,000.0 сая төгрөгийн Дулааны



цахилгаан станцын тоног төхөөрөмж 4 багц



Төмөр замын доогуур гарах нүхэн гарц



Сургуулийн барилга 4, 9-р сургууль



Аймаг, сумын төвийн хатуу хучилттай авто зам 5 багц



Дархан-Уул аймагт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтад орсон гүйцэтгэл

**41.2%**



# "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт" нийцлийн аудитын тайлангаас

## УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ



Дархан-Уул аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 280,125.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 88,132.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 141,249.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 28,199.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 ТАХ нь өмнөх оноос шилжиж ирсэн байна.

### УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО



### УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ



Шинээр төлөвлөсөн ТАХ-ны 72.2 хувийг нэг маягийн зураг, төсөв, хуучин норм стандартад үндэслэн батлуулснаас өөрчлөлт орсон ажлын зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй байна.



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн байна.

## Тайлант онд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл

Боловсрол соёл шинжлэх ухааны сайд 44.6%

Монгол Улсын сайд ОНБТСҮХ 100%

Хүсн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 0 %

Эрчим хүчний сайд 99.7%

Зам тээвэр хөгжлийн сайд 98.2%

Сангийн сайд 82%

Барилга, хот байгуулалтын сайд 79.3%

Эрүүл мэндийн сайд 43%

Соёлын сайд 99.9%

Хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө "Алсын хараа 2050", "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялсан эсэхийг харьцуулан шинжлэхэд төлөвлөсөн ТАХ бүр эгээр бодлого, чиглэлд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэжээ.



# “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт” нийшлийн аудитын тайлангаас

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БҮРТГЭЛД ТУСГАСАН ТАЛААР



31 ажлаас 25 ажлийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй



11,517.0 сая төгрөгийн 6 барилга байгууламж капиталжуулж хөрөнгөд бүртгэсэн байна.



Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнээс 55,625.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 5,451.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтад оруулаагүй байна.

## 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДАЖ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА



### ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Нийт 5 төсөл арга хэмжээ, Төлөвлөсөн 37 ТАХ-ээс 2024 онд 21 ТАХ дутуу хэрэгжсэн дуусаас 16 ТАХ дуусч 71.4 хувийн гүйцэтгэлтэй байна.



### ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ШАЛТГААН

- Компанийн хүчин чадал муу, мэргэжлийн боловсон хүчин дутмаг
- Худалдан авах ажиллагаа хойшилсонтой холбоотой байна.
- Тендер сонгон гүйцэтгэгч шалгараагүйгээс гэрээ байгуулагдаагүй байна.